



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Зардал батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалтууд, Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын санхүүжилтээр хэрэгжих “Монгол Улсад тохиолдож болзошгүй нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхийн үнэлгээ хийх, холбогдох баримт бичгийг боловсруулах” төсөлт ажлыг удирдамжийн дагуу чанартай гүйцэтгэж ажиллахыг Захиргааны албаны Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн (Б.Уянга)-д үүрэг болгосугай.

2.Төсөлт ажлын зардал болох 152,709,040 (Нэг зуун тавин хоёр сая долоон зуун есэн мянга дөчин) төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг нягтлан бодогч (С.Мөнхчимэг)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны дарга (У.Нямжаргал)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АМГАЛАНБАЯР